

БАТЛАВ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ТӨСЛИЙН УДИРДАГЧ
П.ДАВХАРБАЯР
2019 оны 10 сарын 01 -ны өдөр

**“УРАН ЖИРГЭЭ-2019” УРАН УНШЛАГЫН
УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

Зорилго: Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол, бүтээлийг хүүхэд багачуудад таниулах, сурталчлах, уран уншлагын ур чадварыг хөгжүүлэх зорилгоор уг уралдааныг зохион байгуулахад оршино.

Сэдэв:

- Чөлөөт
- Уран унших хугацаа 1-3 минут байна.

Хамрах хүрээ: “УРАН ЖИРГЭЭ -2019” уралдааныг сургуулийн өмнөх нас буюу цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн бага нас 1-5 дугаар анги, сургуулийн дунд нас 6-9 дүгээр анги, сургуулийн ахлах нас 10-12 дугаар анги гэсэн 4 насны ангилалаар шалгаруулна. /Насны ангилал тус бүрд нэг уран уншигчийг шалгаруулна/

Жич: Сургууль, цэцэрлэгүүд анхан шатны шалгаруулалтаа зохион байгуулж, эхний 3 байрт шалгарсан хүүхдүүдийг дүүргийн шалгаруулалтад оролцуулна.

Хугацаа: 2019 оны 10 дугаар сарын 8-ны өдөр дүүргийн хурлын зааланд 09.00 цагт болно.

Уралдааны байр, шагнал /насны ангилал тус бүрээр/

1-р байр нэг, Мөнгөн шагнал, өргөмжлөл, Нийслэлийн уралдаанд оролцох эрхийн бичиг

2-р байр нэг, мөнгөн шагнал, өргөмжлөл, Нийслэлийн уралдаанд оролцох эрхийн бичиг

3-р байр нэг, Мөнгөн шагнал, өргөмжлөл, Нийслэлийн уралдаанд оролцох эрхийн бичиг

Тусгай байр нэг, Мөнгөн шагнал, өргөмжлөл

Шалгарсан сурагчдын анхааралд:

Дүүргийн Уран жиргээ уралдаанд орж, нас насны ангилалд эхний 1, 2, 3-р байр эзэлсэн нийт 12 хүүхдийг хотын наадамд оролцуулна. Улаанбаатар хотын наадамд оролцох сурагчдыг 2019 оны 10-р сарын 9,10-ны өдөр харьяа дүүргийн “Уран жиргээ” уралдаанд оролцож шалгарсан ЭРХИЙН БИЧИГ-ийг үндэслэн бүртгэн авч мандат олгоно. Хотын наадам 2019 оны 10-р сарын 11-ний өдөр Монголын хүүхдийн ордонд болно.

Уралдаанд оролцогчдын мэдүүлгийг 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн дотор НХХ-ийн 502 тоот өрөөнд хүлээн авна. Холбоо барих утас:

99810977,70070128

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР